

□
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 72

Төрийн ордон, Улаанбаатар хот

**ПРОКУРОРЫН АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭГ
ТОГТООХ ТУХАЙ**

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалт, 57.6 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Прокурорын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тогтоосугай.
- 2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Прокурорт нэмэгдэл олгох журам батлах тухай" Улсын Их Хурлын 1996 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Энэ тогтоолыг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР